



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2023/07-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Аудитор: Б.Наранцэцэг
	Утас: 7036-2442 Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-18
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18-22
4. Аудитын тайлан	22-27
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	26
5. Аудитын илрүүлэлт	27-33
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	34-35

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖМС	Жижиг мөнгөн сан
ЗА	Захирагчийн алба
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДНХ	Засаг Даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэр
ХХОАТ	Хүн амын орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв



МАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
А.ДАШЗЭВЭГ ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.25 № 07А/2023/07-НАСДТТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар 9,970,306.1 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 9,082,823.2 төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 91.1 хувьтай тайлагнагдсан бөгөөд батлагдсан төсвийг 887,482.9 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Мандал сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 18.6 хувийг буюу 1,686,712.7 мянган төгрөгийг цалин хөлс, нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд, 17.2 хувийг буюу 564,948.5 мянган төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол

018020395₃

зардалд, 38.9 хувийг буюу хөрөнгийн зардал 3,529,898.1 мянган төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд тус тус зарцуулсан байна.

Тайлант онд сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төв нь тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжсэнээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайл ан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,370,527.90	7,349,826.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,419,026.20	3,674,521.40
33	АВЛАГА	1,216,487.20	951,709.80
35	БАРАА МАТЕРИАЛ	2,735,014.50	2,723,595.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	40,134,958.70	15,126,121.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	40,134,958.70	15,126,121.00
39200	Биет хөрөнгө	36,531,149.50	14,513,193.40
39300	Биет бус хөрөнгө	3,603,809.20	612,927.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	47,505,486.60	22,475,947.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	102,020.30	251,765.60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	102,020.30	251,765.60
41300	Өглөг	102,020.30	251,765.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	47,403,466.20	22,224,182.00
51	Засгийн газрын хувь оролцоо	47,403,466.20	22,224,182.00
51100	Засгийн газрын оруулсан капитал	15,581,909.20	6,107,916.90
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	15,581,909.20	6,107,916.90
51200	Хуримтлагдсан үр дүн	22,757,873.10	14,531,296.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,063,684.00	1,584,968.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	47,505,486.60	22,475,947.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	27,010,256.80	13,450,343.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,971,921.70	8,002,393.60
110	Орлогын албан татвар	900,547.70	4,859,183.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	900,547.70	4,859,183.70
113	Хөрөнгийн албан татвар	145,884.60	587,986.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,925,489.40	2,555,223.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,224,092.20	2,268,322.60
120	Нийтлэг татварын бус орлого	6,224,092.20	2,268,322.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,814,242.80	3,179,627.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	27,010,256.80	8,679,200.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,542,793.90	7,588,341.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,721,982.40	5,585,900.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,103,729.60	1,509,225.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,320,881.30	186,262.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,240,760.90	1,564,948.40
2104	Хангамж, бараа материалын зардал	407,838.40	125,835.90
2105	Нормативт зардал	529,298.90	2,971.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,884.60	392,963.00
2107	Томилолт, зочны зардал	15,570.50	7,746.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,051,271.90	1,088,308.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,851,746.30	707,639.60
212	ТАТААС	223,614.10	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	597,197.40	2,002,440.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	1,090,859.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	8,467,462.80	4,771,142.80
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,582,483.90	29,507,038.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,884,978.90	-24,735,895.60

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	28,264,623.40	12,344,645.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,971,921.70	8,002,393.60
110	Орлогын албан татвар	900,547.70	4,859,183.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	900,547.70	4,859,183.70
113	Хөрөнгийн албан татвар	145,884.60	587,986.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,925,489.40	2,555,223.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	283,758.10	346,943.00
1181	Газрын төлбөр	99,293.00	586,232.40
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,542,438.40	1,622,047.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,449,781.30	1,038,688.60
120	Нийтлэг татварын бус орлого	1,449,781.30	1,038,688.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	22,842,920.50	3,303,563.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,189,514.60	7,348,496.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,189,514.60	7,348,496.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,094,140.80	5,317,851.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,110,459.40	1,509,082.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,322,841.70	186,288.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,245,267.60	1,564,948.40
2104	Хангамж, бараа материалын зардал	229,656.70	104,644.40
2105	Нормативт зардал	563,168.80	1,893.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210,313.90	424,369.40
2107	Томилолт, зочны зардал	15,570.50	7,746.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,107,160.70	1,055,045.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,289,701.80	463,832.40
212	ТАТААС	223,614.10	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,871,759.70	2,030,645.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,075,108.80	4,996,148.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,389,768.80	4,510,653.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,389,768.80	4,510,653.60
2200	Дотоод эх үүсвэрээр	3,389,768.80	4,510,653.60
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,389,768.80	-4,510,653.60
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-473,000.00	-230,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	473,000.00	230,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,212,340.00	255,495.20
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,206,686.20	3,419,026.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,419,026.20	3,674,521.40

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,423,546.20	0	44,423,546.20
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	46,044.00	0	46,044.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,469,590.20	0	44,469,590.20
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-32,557.90	0	-32,557.90
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	81,455.00	0	81,455.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0
7	Зарласан ногдол ашиг	0	0	0
8	Тайлант үеийн үр дүн	2,884,978.90	0	2,884,978.90
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	47,403,466.30	0	47,403,466.30
10	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	47,403,466.30	0	47,403,466.30
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-12,114,376.20	0	-12,114,376.20
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,289,090.10	0	35,289,090.10
14	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
15	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0
16	Зарласан ногдол ашиг	0	0	0
17	Тайлант үеийн үр дүн	-24,735,895.60	0	-24,735,895.60
18	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,224,182.00	0	22,224,182.00

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,970,306.10	9,082,823.19	887,482.91	91.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,579,292.40	5,322,925.07	256,367.33	95.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,366,668.60	5,111,379.55	255,289.05	95.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,536,964.00	1,500,486.89	36,477.11	97.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	193,226.00	186,225.79	7,000.21	96.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,588,946.60	1,564,948.45	23,998.15	98.5
2104	Хангамж, бараа материалын зардал	88,411.10	87,572.59	838.51	99.0
2105	Нормативт зардал	2,022.10	1,893.00	129.10	93.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	441,483.50	441,139.51	343.99	99.9
2107	Томилолт, зочны зардал	10,335.60	7,746.05	2,589.55	74.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,480,140.10	1,303,049.75	177,090.35	88.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,139.60	18,317.51	6,822.09	72.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	212,623.80	211,545.52	1,078.28	99.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,969,163.70	3,529,898.13	439,265.58	88.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	421,850.00	230,000.00	191,850.00	54.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,970,306.10	9,048,434.40	921,871.70	90.7
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,107,686.10	8,721,895.44	385,790.66	95.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	712,620.00	326,538.97	386,081.03	45.8
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	150,000.00	0	150,000.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	559,533.70		0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	441,605.91		0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	555	219	336.00	39.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5	5	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	275	107	168.00	38.9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,654,058.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,014,217.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	547,385.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,596.00
2102	Ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл	63.0
2104	Хангамж, бараа материалын зардал	17,017.78
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,812.62
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	47,327.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	445,514.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	466,831.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	465,831.35
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	639,841.55
2251	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	639,841.55
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,654,053.73
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,654,053.73
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-4.82
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4.82
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Мандал сумын ТТЗ гэх/ нь 2022 оны үйл ажиллагааны зорилгыг “Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх дэвшүүлсэн зорилтын хүрээнд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн болон сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, аймаг, сумдын ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнаж ажиллах,
- Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих,
- Төр иргэний харилцан итгэлцлийг хангасан чадварлаг засаглалын бодлогыг хэрэгжүүлэх,
- Иргэн бүрийг хөдөлмөрлөх ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэн иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулах,
- Орон нутгийн түүхий эдийн бааз суурь дээр тулгуурлан жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйг түлхүү хөгжүүлэх,
- Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлж, соёл уламжлалаа дээдэлдэг иргэнийг төлөвшүүлэх,
- Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,

- ЗГ-ын 2022 оны 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”-д өөрчлөлт оруулсан,
- Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлөгдөх, хяналт тавих журамд ХХААХҮ-ийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 26-ны А/243 тушаалаар журамд нэмэлт өөрчлөлт оруулсан,
- “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”, “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяалагдах төсөвт байгууллагуудын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,029,539.0 мянган төгрөгөөр буюу 47.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,419,026.2	3,674,521.4	255,495.2
Авлага	1,216,487.2	951,709.8	(264,777.4)
Бараа материал	2,735,014.5	2,723,595.3	(11,419.2)
Үндсэн хөрөнгө	40,134,958.7	15,126,121.0	(25,008,837.6)
Нийт хөрөнгө	47,505,486.6	22,475,947.6	(25,029,539.0)
Өр төлбөр	102,020.3	251,765.6	149,745.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	47,403,466.3	22,224,182.0	(25,179,284.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	47,505,486.6	22,475,947.6	(25,029,539.0)

Дээрх хүснэгтээс харахад, нийт хөрөнгийн үлдэгдэл 22,475,947.6 мянган төгрөг болж, 25,029,539.0 мянган төгрөгөөр буурсан нь бүтцийн өөрчлөлтөөр ЭМТ, Соёлын төв, ЕБС, цэцэрлэгүүдийн 29,606,708.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,270,784.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 3,419,026.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 3,674,521.4 мянган төгрөг болж, 255,495.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	3,419,026.2	3,674,521.4	255,495.2
Дүн	3,419,026.2	3,674,521.4	255,495.2

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан ОНЕО-ын дансанд 3,232,915.5 мянган төгрөг, ОНХС-ийн дансанд 232,078.5 мянган төгрөг, ХХС-ийн дансанд 168,186.8 мянган төгрөг, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний дансанд 41,340.6 мянган төгрөг зэрэг нийт 3,674,521.4 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

Баяр наадмын арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллагуудаас ЖМС-ийн дансанд төвлөрүүлсэн нийт **30,000.0** мянган төгрөгийг төрийн сангийн дансанд тушаалгүйгээр зарцуулсан.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,216,487.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 951,709.8 мянган төгрөг болж, 264,777.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татаас санхүүжилтийн авлага	242,235.3	-	(242,235.3)
Хувь хүмүүсээс авах авлага	159.0	-	(159.0)
Хувь хүмүүст олгосон зээл	945,197.7	910,673.9	(34,523.8)
Зээлийн хүүгийн авлага	28,895.2	41,035.9	12,140.6
Дүн	1,216,487.2	951,709.8	(264,777.4)

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд ХХС-тай холбоотой зээлийн 910,673.9 мянган төгрөг, зээлийн хүүгийн 41,035.9 мянган төгрөг зэрэг нийт 951,709.8 мянган төгрөгийн авлага тус тус тайлагнагдсан байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 2,735,014.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,723,595.3 мянган төгрөг болж, 11,419.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	173,412.5	4,184.7	(169,227.8)
Эм боох материал	104,952.2	127.5	(104,824.7)
Бичиг хэргийн материал	14,295.9	5,033.9	(9,262.0)
Аж ахуйн материал	327,623.3	45,707.5	(281,915.8)
Барилгын засварын материал	37,890.9	22,918.0	(14,972.9)
Хүнсний материал	12,984.5	0.0	(12,984.5)
Бусад хангамжийн материал	2,052,305.7	2,643,268.7	590,963.0
Түлш шатах тослох материал	9,704.5	0.0	(9,704.5)
Сэлбэг хэрэгсэл	1,845.0	2,355.0	510.0
Дүн	2,735,014.5	2,723,595.3	(11,419.2)

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 11,419.2 мянган төгрөгөөр буурсан нь дараах ажил, гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 3,758,756.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 70.0 мянган төгрөгийн вирусын программ, дээд шатны байгууллагаас 92,677.5 мянган төгрөгийн ойн менежментийн төлөвлөгөө, зураг төсөв зэргийг хүлээн авсан,
- 1,202,205.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн 1,389,932.6 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг бараа материалын дансаар дамжуулан ашиглагч байгууллагуудад тус тус шилжүүлсэн болон бүтцийн өөрчлөлөөр ЕБС, ЭМТ, Соёлын төв, цэцэрлэгүүдийн нийт 1,270,784.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн гэх мэт.

Аудитын илрүүлэлт:

Мандал сумын ТТЗ-ийн харьяаны дараах байгууллагууд нь нийт **39,930.2** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна. Үүнд:

- ИТХ нь 2,920.5 мянган төгрөг,
- ЗДТГ нь 35,220.7 мянган төгрөг,
- Хэрх тосгоны ЗА нь 536.8 мянган төгрөг,
- Түнхэл тосгоны ЗА нь 403.1 мянган төгрөг,
- Ойн анги нь 849.1 мянган төгрөг.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 46,128,709.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 18,031,477.5 мянган төгрөг болж, 28,097,232.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	28,357,899.7	7,956,945.8	(20,400,953.9)
Авто-тээврийн хэрэгсэл	959,836.8	377,869.7	(581,967.1)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,720,887.1	925,208.8	(1,795,678.3)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,287,339.4	185,476.3	(1,101,863.1)
Зам, гүүрийн байгууламж	3,761,518.3	4,321,330.3	559,812.0
Дуусаагүй барилга байгууламж	3,482,383.5	2,704,079.0	(778,304.5)
Ном	365,097.3	450.9	(364,646.4)
Бусад үндсэн хөрөнгө	1,578,748.5	944,205.5	(634,543.0)
Программ хангамж	27,412.1	6,053.5	(21,358.6)
Бусад биет бус хөрөнгө	3,587,586.9	609,857.7	(2,977,729.2)
Дүн	46,128,709.6	18,031,477.5	(28,097,232.1)

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 28,097,232.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 340,913.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, хандиваар 64,211.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил хүлээн авсан, аймаг, сумын ОНХС-ийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1,872,451.4 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 128,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан, балансас балансад 640,100.2 мянган төгрөгийг шилжүүлсэн, бүтцийн өөрчлөлтөөр ЭМТ, Соёлын төв, ЕБС, цэцэрлэгүүдийн нийт 29,606,708.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

Дуусаагүй барилга дансанд 2,704,079.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд:

- Тарнийн 8 дугаар багийн барилгын 40,000.0 мянган төгрөгийн, /цэвдэгтэй газар баригдаад улсын комисс ашиглалтад хүлээж аваагүйгээс /

- Авто замын 1,070,983.5 мянган төгрөгийн /2018 онд хийгдсэн замын ажил нь хүлээж авсан акт байхгүйгээс үлдэгдлээр тайлагнагдсан байна/,
- ЗДТГ-ын дотоод засварын ажлын 514,729.1 мянган төгрөгийн /2022 онд хэрэгжиж эхэлсэн бөгөөд он дамжин хийгдэж буй ажил/,
- Түнхэл тосгоны төрийн албан хаагчийн байр болон соёл спортын цогцолборын барилгын 1,078,366.4 мянган төгрөгийн /Барилгын хөгжлийн төвөөс зөвшөөрөл гараагүйгээс улсын комисс хүлээж аваагүй байна/ дуусаагүй барилга тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Дараах байгууллагуудын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 125 нэр төрлийн үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. Үүнд:

- ИТХ нь 14 нэр төрлийн,
- ЗДТГ нь 59 нэр төрлийн,
- Ойн анги нь 10 нэр төрлийн,
- Хэрх тосгоны Захирагчийн алба нь 5 нэр төрлийн,
- Түнхэл тосгоны Захирагчийн алба нь 20 нэр төрлийн.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 102,020.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 251,765.6 мянган төгрөг болж 149,745.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	81,059.7	251,070.5	170,010.8
Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	695.1	695.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	20,960.6	0.0	(20,960.6)
Дүн	102,020.3	251,765.6	149,745.3

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Өр төлбөрийн үлдэгдэлд: байгаль хамгаалах сангийн дансанд хувь хүнд төлөх өглөгийн 695.1 мянган төгрөг, зам засварын үлдэгдэл санхүүжилтийн байгууллагад төлөх өглөгийн 29,206.9 мянган төгрөг, ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын барьцаа 221,863.6 мянган төгрөгийн зэрэг өр төлбөр тус тус тайлагнагдсан байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 47,403,466.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 22,224,182.0 мянган төгрөг болж, 25,179,284.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	15,581,909.2	6,107,916.9	(9,473,992.3)
Хуримтлагдсан үр дүн	22,757,873.1	14,531,296.9	(8,226,576.2)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,063,684.0	1,584,968.2	(7,478,715.7)
Дүн	47,403,466.3	22,224,182.0	(25,179,284.3)

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь ЭМТ, соёлын төв, ЕБС, цэцэрлэг зэрэг байгууллагууд нь хаалтын тайлан гаргаж, засгийн газрын санг бууруулан бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.7 Орлогын данс

Тайлант онд 6,757,360.9 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 8,788,829.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 130.1 хувиар биелүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Үйл ажиллагааны буюу өөрийн орлогыг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллаагүйгээс орлогын төлөвлөгөөг нийт **1,187.9** мянган төгрөгөөр тасалсан байна. Үүнд:

- ЗДТГ нь 500.0 мянган төгрөг,
- Түнхэл тосгоны Захирагчийн алба нь 687.9 мянган төгрөг,

3.4.8 Зардлын данс

Төсвийн нийт зарлагыг 9,970,306.1 мянган төгрөгөөр төлөвлөн баталж, гүйцэтгэлээр 9,082,823.2 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 91.1 хувьтай тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ ИТХ нь гэрээт ажилтнаар ажиллаж байсан С.Ичинхорлоод 1 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд үндсэн цалингийн 40 хувиар тооцож **631.5** мянган төгрөг олгосон,
- ✓ “Тэнгисийн энерги” ХХК-д гэрээт ажлын санхүүжилтийг **2,575.5** мянган төгрөгөөр илүү олгосон,
- ✓ Сумын Засаг даргын захирамжаар ТТЗ-ийн харьяа байгууллагуудын нягтлан бодогч, төрийн сангийн мэргэжилтэн нарт сарын үндсэн цалингийн 100 хувиар тооцон нийт **5,568.7** мянган төгрөгийн шагнал, урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон,

- ✓ Нэг удаагийн тэтгэмж урамшууллын батлагдсан төсвөөс нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн арга хэмжээнд **23,607.0** мянган төгрөг зарцуулсан,
- ✓ ЗДТГ-ын ахмад настны хөгжил хамгааллын зардлаас “Энх мэнд сувилал” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны урсгал зардалд 3,000.0 мянган төгрөг, тус сувиллын эмч Х.Энхбилэгт орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт тасралтгүй ажиллаж буй гэх үндэслэлээр нэг удаагийн тэтгэмжид 3,840.4 мянган төгрөг зэрэг нийт **6,840.4** мянган төгрөгийг тус тус зарцуулсан,
- ✓ Дараах байгууллагууд нийт **9,718.6** мянган төгрөгийг зардлын бүлэг болон хөтөлбөр хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулсан. Үүнд:
 - ЗДТГ 8,179.0 мянган төгрөг,
 - ИТХ нь 999.8 мянган төгрөг,
 - Хэрх тосгоны Захирагчийн алба нь 539.8 мянган төгрөг.
- ✓ Дараах байгууллагууд нь Өмч хамгаалах зөвлөлөөр автомашинд засвар, үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх техникийн комиссын дүгнэлт, актгүйгээр засвар үйлчилгээнд ний **9,252.2** мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл, тайланд тусгасан. Үүнд:
 - ЗДТГ нь 2,966.2 мянган төгрөг,
 - Ойн анги нь 6,286.0 мянган төгрөг.
- ✓ ИТХ нь анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт **5,360.7** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 64 дүгээр тогтоолоор Мандал сум нь тайлант онд 6,757,360.9 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 8,788,829.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 130.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/					
д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар	3,598,952.0	3,916,633.4	317,681.4	108.8
2	Үйл ажиллагааны орлого	160,000.0	376,297.2	216,297.2	235.2
3	Хөрөнгийн татвар	195,000.0	250,302.2	55,302.2	128.4

4	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	504,000.0	419,688.8	(84,311.2)	83.3
5	Хадгаламжийн хүүгийн орлого	320,000.0	315,950.9	(4,049.1)	98.7
6	Бууны албан татвар	12,000.0	12,158.0	158.0	101.3
7	Малын тоо толгойн албан татвар	254,531.7	156,139.8	(98,391.9)	61.3
8	Улсын тэмдэгийн хураамж	48,000.0	113,818.4	65,818.4	237.1
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	22,000.0	96,071.6	74,071.6	4 дахин
10	Газрын төлбөр	291,340.1	157,545.7	(133,794.4)	54.1
11	Дуудлага худалдааны орлого	52,600.0	428,686.7	376,086.7	8 дахин
12	Ус ашигласны төлбөр	5,000.0	3,674.8	(1,325.2)	73.5
13	Ойн нөөц ашигласны төлбөр	518,404.7	1,607,690.6	1,089,285.9	310.1
14	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.0	1,012.5	1,023.5	100.0
15	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2,326.0	9,659.0	7,333.0	4 дахин
16	Хог хаягдлын хураамжийн орлого	150,000.0	137,052.9	(12,947.1)	91.4
17	Хүү, торгуулийн орлого	400,000.0	549,137.0	149,137.0	137.3
18	Бусад орлого	223,206.4	237,299.0	14,092.6	106.3
	Нийт дүн	6,757,360.9	8,788,829.5	2,031,468.6	130.1

Орлогын төлөвлөгөө 2,031,468.6 мянган төгрөгөөр давж биелсэн нь дуудлага худалдаа, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, ойн нөөц ашигласны төлбөр зэрэг орлогууд давж биелсэнтэй холбоотой байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давсан орлого

- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 1,089,285.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь Хан Хэнтий улсын тусгай хамгаалалттай газраас бэлтгэх модны болон хуш модны самар бэлтгэх гэрээ хийгдсэнтэй холбоотой байна.
- Дуудлага худалдааны орлого 376,086.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь газрын дуудлага худалдааны үнэ өссөнтэй холбоотой байна.
- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 317,681.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотой байна.

Тасарсан орлого:

- Малын тоо толгойн албан татвар 98,391.9 мянган төгрөгөөр,
- Газрын төлбөр 133,794.4 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь дотоод ажлын зохион байгуулалт муугаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас төвлөрүүлэх татварыг дутуу төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг 5,827,014.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөсөн байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 32 дугаар тогтоолоор:

- Орон нутгийн төсвийн орлогыг 6,858,408.9 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 1,921,723.2 мянган төгрөг,
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 65,000.0 мянган төгрөг,
- Урьд оны үлдэгдлээс 162,052.5 мянган төгрөг,
- ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 2,160,000.0 мянган төгрөг,
- Сумын төсөвт аймгийн ОНХС-аас олгох хот тохижуулалтын 77,267.4 мянган төгрөг,
- ХХС-ийн 431,550.0 мянган төгрөг зэрэг сумын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг **11,676,002.0** мянган төгрөг, зарлагыг 10,750,797.6 мянган төгрөгөөр, аймгийн төсөвт **925,204.4** мянган төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 55 дугаар тогтоолоор аймгийн 2022 оны төсвийг тодотгосонтой холбоотойгоор сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор:

- Орон нутгийн төсвийн орлогыг 101,048.0 мянган төгрөгөөр бууруулан 6,757,360.9 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 1,921,723.2 мянган төгрөг,
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 65,000.0 мянган төгрөг,
- Урьд оны үлдэгдлээс 216,070.0 мянган төгрөг,
- ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 2,160,000.0 мянган төгрөг,
- Сумын төсөвт аймгийн ОНХС-аас олгох хот тохижуулалтын 77,267.4 мянган төгрөг,
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн орлогыг 150,000.0 мянган төгрөг,
- ХХС-ийн 431,550.0 мянган төгрөг зэрэг сумын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг **11,778,971.5** мянган төгрөг, зарлагыг 9,970,306.1 мянган төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг **1,808,665.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогыг 8,788,829.5 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 65,000.0 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 1,921,723.2 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 216,070.0 мянган төгрөгийг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 2,160,000.0 мянган төгрөг, сумын төсөвт аймгийн ОНХС-аас олгох хот тохижуулалтын 77,267.4 мянган төгрөг, ХХС-ийн 230,000.0 мянган төгрөгийн зэрэг нийт **13,458,890.1** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн, 1,808,665.4 мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **9,082,823.2** мянган төгрөг буюу 91.1 хувьтай тайлагнагдсан нь ХХС-ийн зээл болон ТШЗ-д орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт зэргээс шалтгаалсан байна. Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал:

- ✓ Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 36,477.1 мянган төгрөгөөр,
- ✓ Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 7,000.2 мянган төгрөгөөр,
- ✓ Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 23,998.2 мянган төгрөгөөр,
- ✓ Хангамж, бараа материалын зардал 838.5 мянган төгрөгөөр,
- ✓ Нормативт зардал 129.1 мянган төгрөгөөр,
- ✓ Эд хогшил, урсгал засварын зардал 344.0 мянган төгрөгөөр,
- ✓ Албан томилолтын зардал 2,589.6 мянган төгрөгөөр,
- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 177,090.3 мянган төгрөгөөр,
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардал 6,822.1 мянган төгрөгөөр,
- ✓ Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 1,078.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 14 төсөл, арга хэмжээнд 1,831,370.5 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 1,541,514.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 289,856.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 4 төсөл, арга хэмжээ хэрэгжиж дуусаагүй, он дамжсанаас шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 13 төсөл, арга хэмжээнд 2,137,793.2 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 1,988,383.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 149,409.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 1 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 3,4 дүгээр багт хүүхдийн тоглоомын талбай барих ажлын гүйцэтгэгч байгууллага чанарын шаардлага хангаагүй ажил гүйцэтгэснээс уг ажлыг зогсоосон зэргээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 482,878.4 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчдаас 1,134,346.4 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс 6,828.9 мянган төгрөг, иргэд, аж ахуйн нэгж

байгууллагаас 30,000.0 мянган төгрөгийн хандив тусламж зэрэг нийт **1,654,053.7** мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнээс:

- ✓ Цалин хөлсөнд 8,596.0 мянган төгрөг,
 - ✓ Ажил олгогчоос олгох НДШ-ийн зардалд 63.0 мянган төгрөг,
 - ✓ Хангамж бараа материалын зардалд 17,071.8 мянган төгрөг,
 - ✓ Эд хогшил, урсгал засварын зардалд 28,812.6 мянган төгрөг,
 - ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 47,327.4 мянган төгрөг,
 - ✓ Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 1,000.0 мянган төгрөг,
 - ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 445,514.9 мянган төгрөг,
 - ✓ Биет болон биет бус хөрөнгө худалдан авахад 639,841.6 мянган төгрөг
- зэрэг нийт **1,188,227.3** мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 465,831.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагч цаашид *Мандал сумын ТТЗ гэх/*-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт гүйцэтгэл, нягтлан болох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлт, үндсэн хөрөнгө болон нэмэгдэл цалин хөлстэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/120 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн

нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үзлээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 27,010,256.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 270,102.6 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан ЕБС, ЭМТ, Соёлын төв, цэцэрлэг зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан нь тус тусын яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 8,679,200.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон **130,188.0** мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 01/633 дугаар "Үүрэг чиглэл өгөх тухай" албан бичгээр төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажиллахыг чиглэл болгосны дагуу дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

- ✓ Сумын ЕБС, цэцэрлэг, политехникийн коллеж, баг хороо, ЗДТГ, ЭМТ зэрэг байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтийг бууруулсан,
- ✓ Бичиг хэргийн зардлыг боломжит түвшин хүртэл хэмнэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтуудыг зөрчсөн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

ЗДТГ:

- ✓ Нэг удаагийн тэтгэмж урамшууллын батлагдсан төсвөөс аймгийн ИТХ-ын дарга Б.Нарантуяад 500.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон,
- ✓ Төрийн одон медаль авсан албан хаагчдад /С.Энхтуяа, Т.Цэцэгмаа, Ж.Волоож/ 900.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл /мөнгөн аяга/ олгосон,
- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 4,112.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэсэн,
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс хөдөлмөр, авьяас, ур чадвараараа бусдыгаа манлайлж сум орон нутгийнхаа нэрийг улс, аймагтаа өндөрт гаргасан зүтгэлийг үнэлж Ж.Од, Ч.Чинбат, Д.Батбаяр, Г.Ансай, Г.Бат-Эрдэнэ, Х.Наранбаатар нэрт нийт 4,500.0 мянган төгрөгийн шагнал олгосон,

ИТХ:

- ✓ Нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн арга хэмжээнд 21,537.0 мянган төгрөг /18,770.0 мянган төгрөгийг тэмдэглэлийн дэвтэр, аяга, ном зэрэг гарын бэлэг авахад, 1,500.0 мянган төгрөгийг сонин хэвлэхэд, 1,267.0 мянган төгрөгийг самбар, хаяг, жааз хэвлүүлэхэд/.

- ✓ Хараа бүсийн спортын арга хэмжээний шагналд 1,550.0 мянган төгрөг,
- ✓ Өмнөговь аймагт туршлага судлахад 520.0 мянган төгрөг.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15.1.5: “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.2 дахь “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3: “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сумын ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт № 8 ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Огт мэдээлээгүй
1	ТТЗ	162	162		
2	Засаг даргын тамгын газар	160	156	4	
3	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	160	159	1	
4	Хэрх тосгоны Захирагчийн алба	160	160		
5	Түнхэл тосгоны Захирагчийн алба	160	145	15	
6	Ойн анги	160	160		
	Нийт дүн	1122	1102	20	

Түнхэл тосгоны Захирагчийн алба нь мэдээлбэл зохих 160 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь, 15 мэдээллийг хугацаа хоцроож, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. /Шилэн дансны мэдээллийг мэдээлэх чиг үүрэг бүхий Түнхэл тосгоны Захирагчийн албаны нягтлан бодогч Б.Хишигням үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн/

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль, тогтоомжийн хүрээнд:

Төсвийг холбогдох хөтөлбөр, төсвийн ангилалд нь үнэн зөв төлөвлөөгүй дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зардалд тусгагдсан гэх үндэслэлээр 272,576.2 мянган төгрөгийн өртөг бүхий "Мэдээлэл шуурхай удирдлагын жишиг төв" байгуулах төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын бус Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардалд тусгаж, хэрэгжүүлсэн байна. Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2: "Төсвийн ... үнэн зөв байдлыг хангах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Төсөл, хөтөлбөрийн зураг төсөв боловсруулах 10,881.6 мянган төгрөгийг ОНХС-ийн төсөвт бус ОНХО-ын төсөвт тусган баталж, хэрэгжүүлсэн нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх "Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль, энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга, байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ, 4.4.5: "Сум дүүргийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,466.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 165,215.4 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн,

450,158.8 мянган төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 84.2 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	5,466.2	1	5,466.2	100.0
Албан шаардлага	10	165,215.4	9	162,385.1	90.0
Зөвлөмж	8	450,158.8	6	37,038.5	75.0
Нийт дүн	19	620,840.4	16	207,720.1	84.2

Өмнөх аудитаар өгсөн бараа материалын худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй болон зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг шалгаж амжаагүй тул Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

2. Санхүүгийн тайланд тусгагдсан Сум хөгжүүлэх сангаас /Хоршоог хөгжүүлэх сан/ 2011-2019 онуудад олгогдсон 20 иргэний нийт 411,944.3 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байгаа бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй хамтран ажиллаж зээлийг барагдуулах арга хэмжээ авч байгаа хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна. Иймд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

3. Тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд хийх аудитаар авч үзэх нь зүйтэй байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн Б/29 дүгээр захирамжаар 2021 оны санхүүгийн тайланг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр сумын Санхүүгийн албаны даргад үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж олгох шийдвэрийг үндэслэн 1,617.8 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 75,004.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулж, 51,493.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаанд зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа:

- ✓ ИТХ нь 16,504.7 мянган төгрөгийн, ЗДТГ нь 44,533.5 мянган төгрөгийн, Хэрх тосгоны Захирагчийн алба нь 8,465.9 мянган төгрөгийн өр төлбөрийн хариуцагчдын нэр, тооцоог зөрүүтэй илэрхийлснээс өр төлбөр дансны дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдэл санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдлээс 69,504.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- ✓ Хэрх тосгоны Захирагчийн алба нь 5,500.0 мянган төгрөгийн барилгын засварын материалыг сэлбэг хэрэгсэл дансанд ангилал буруу бүртгэснийг тус тус аудитын явцад залруулав.

Залруулагдаагүй алдаа:

- ✓ Ойн анги нь хангамжийн бараа материалын зардлын дансыг сонгохдоо цалингийн зардлын 210101, 210104 тоот дансанд **160.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэж, тайлагнасан,
- ✓ ИТХ нь аймгийн ГХУССЗ-өөс тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлж, мэдээллийн шуурхай удирдлагын төвд эд хогшил худалдан авсан **10,000.0** мянган төгрөгийг шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн,
- ✓ ЗДТГ нь бараа материалын дансаар дамжуулан замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн замын тэмдэглэгээний **19,927.1** мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэхдээ хасах дүнгээр илэрхийлсэн,
- ✓ ЗДТГ нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 28 нэр төрлийн хөрөнгийн үлдэх өртгийг **21,406.1** мянган төгрөгөөр хасах дүнгээр илэрхийлж, үлдэх өртгийн дүнг бууруулсан байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийх зөвлөмж өгөв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн боллогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга халдсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 144,684.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 3,207.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 96,864.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 44,612.9 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. ЗДТГ нь "Мэдээллийн шуурхай удирдлагын жишиг төв байгуулах" ажлыг хийж гүйцэтгэсэн "Тэнгисийн энерги" ХХК-д гэрээт ажлын санхүүжилтийг **2,575.5** мянган төгрөгөөр илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-дахь *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон санхүүжилтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. ИТХ нь өндөр насны тэтгэвэр тогтоолгож, гэрээт ажилтнаар ажиллаж байсан С.Ичинхорлоод 1 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал гэж үндсэн цалингийн 40 хувьтай тэнцэх **631.5** мянган төгрөг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан *"Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1 дэх "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага:

ТТЗ:

1. Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн Б/29 дүгээр захирамжийг үндэслэн сумын Засаг даргын 2022 А/297 дугаар захирамжаар 2021 оны санхүүгийн тайланг "Зөрчилгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр төрийн сангийн мэргэжилтэн болон харьяа байгууллагуудын нягтлан бодогчдод сарын үндсэн цалингийн 100 хувиар тооцон нийт **5,568.7** мянган төгрөгийн шагнал, урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан *"Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан*

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгохгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Дараах байгууллагууд батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал, хөтөлбөр хооронд гүйлгэн зориулалт бусаар нийт **40,166.0** мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

ИТХ:

- ✓ Нэг удаагийн тэтгэмж урамшууллын батлагдсан төсвөөс нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн арга хэмжээнд 21,537.0 мянган төгрөг /18,770.0 мянган төгрөгийг тэмдэглэлийн дэвтэр, аяга, ном зэрэг гарын бэлэг авахад, 1,500.0 мянган төгрөгийг сонин хэвлэхэд, 1,267.0 мянган төгрөгийг самбар, хаяг, жааз хэвлүүлэхэд/, Хараа бүсийн спортын арга хэмжээний шагналд 1,550.0 мянган төгрөг зэрэг нийт **23,087.0** мянган төгрөг,
- ✓ Өмнөговь аймагт туршлага судлахад нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 345.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 175.0 мянган төгрөг зэрэг нийт 520.0 мянган төгрөг,
- ✓ Мэдээлэл сурталчилгааны зардлаас хуралдааны зардалд 999.8 мянган төгрөг зэрэг нийт **24,606.8** мянган төгрөг,

ЗДТГ:

- ✓ Ахмад настны хөгжил хамгааллын хөтөлбөрийн зардлаас “Энх мэнд сувилал” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны урсгал зардалд 3,000.0 мянган төгрөг, тус сувиллын дарга Х.Энхбилэгт орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт тасралтгүй ажиллаж буй гэх үндэслэлээр нэг удаагийн тэтгэмжид 3,840.4 мянган төгрөг зэрэг нийт **6,840.4** мянган төгрөг,
- ✓ Хог хаягдал зайлуулах зардлаас урсгал засварт 5,441.0 мянган төгрөг,
- ✓ Хичээл үйлдвэрлэлийн төсвөөс бараа ажил үйлчилгээний бусад зардалд 1,388.0 мянган төгрөг,
- ✓ Үндсэн үйл ажиллагааны зардлаас Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс хэрэгжсэн “Мэдээллийн шуурхай удирдлагын жишиг төв байгуулах” арга хэмжээнд 1,350.0 мянган төгрөг зэрэг нийт **15,019.4** мянган төгрөг.

Хэрх тосгоны Захирагчийн алба:

- ✓ Цалин хөлсний зардлаас ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд **539.8** мянган төгрөг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-дэх “Төсвийн байгууллага, төрийн болон

орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15.1.5: “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 15.2 дахь “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3: “Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтууд болон Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

3. ЗДТГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүйгээс нийт **10,012.0** мянган төгрөгийн зөрчил гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.5: “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- ✓ Нэг удаагийн тэтгэмж урамшууллын батлагдсан төсвөөс аймгийн ИТХ-ын дарга Б.Нарантуяад **500.0** мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон,
- ✓ Төрийн одон медаль авсан албан хаагчдад /С.Энхтуяа, Т.Цэцэгмаа, Ж.Волоож/ **900.0** мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл /мөнгөн аяга/ олгосон,
- ✓ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас **4,112.0** мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэж, оны эцэст бөөн дүнгээр зарлагдсан /3,858.0 мянган төгрөгийн 100 ширхэг бэлгийн хайрцаг, 254.0 мянган төгрөгийн 400 ширхэг нэрийн хуудас/,
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс хөдөлмөр, авьяас, ур чадвараараа бусдыгаа манлайлж сум орон нутгийнхаа нэрийг улс, аймагтаа өндөрт гаргасан зүтгэлийг үнэлж Ж.Од, Ч.Чинбат, Д.Батбаяр, Г.Ансай, Г.Бат-Эрдэнэ, Х.Наранбаатар зэрэг хүмүүст нийт **4,500.0** мянган төгрөгийн шагнал олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4. Дараах байгууллагууд өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр нийт **39,930.2** мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч

борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- ✓ ИТХ 2,920.5 мянган төгрөг,
- ✓ ЗДТГ 35,220.7 мянган төгрөг,
- ✓ Хэрх тосгоны Захирагчийн алба 536.8 мянган төгрөг,
- ✓ Түнхэл тосгоны Захирагчийн алба 403.1 мянган төгрөг,
- ✓ Ойн анги 849.1 мянган төгрөг зэрэг.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

5. Дараах байгууллагууд үндсэн үйл ажиллагааны буюу өөрийн орлогын төлөвлөгөөг нийт **1,187.9** мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- ✓ ЗДТГ нь 500.0 мянган төгрөг,
- ✓ Түнхэл тосгоны Захирагчийн алба нь 687.9 мянган төгрөг.

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ИТХ нь анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт **5,360.7** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

- ✓ Нэхэмжлэх, шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасгүйгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 10 иргэнийг архины албадан эмчилгээнд хамруулахад 772.4 мянган төгрөг,
- ✓ Шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудасгүйгээр үндсэн үйл ажиллагааны шатахууны зардалд 4,588.3 мянган төгрөг,

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл, тайланд тусгаж байх.

Илрүүлэлт: Дараах байгууллагууд нь Өмч хамгаалах зөвлөлөөр автомашинд засвар, үйлчилгээ, зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх техникийн комиссын дүгнэлт, актгүйгээр засвар үйлчилгээнд ний **9,252.2** мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл, тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- ✓ ЗДТГ нь 2,966.2 мянган төгрөг,
- ✓ Ойн анги нь 6,286.0 мянган төгрөг,

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр, техникийн комиссын акт, дүгнэлтийг үндэслэн авто машины засвар үйлчилгээг гүйцэтгэж байх.

Илрүүлэлт: Баяр наадмын арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллагуудаас ЖМС-ийн дансанд төвлөрүүлсэн нийт **30,000.0** мянган төгрөгийг төрийн сангийн дансанд тушаалгүйгээр зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6 дахь "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: ЖМС-д хүлээн авсан орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, холбогдох хууль, журмын хүрээнд зарцуулах.

Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Дараах байгууллагуудын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 125 нэр төрлийн үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- ✓ ИТХ нь 14 нэр төрлийн,
- ✓ ЗДТГ нь 59 нэр төрлийн,
- ✓ Ойн анги нь 10 нэр төрлийн,
- ✓ Хэрх тосгоны Захирагчийн алба нь 5 нэр төрлийн,
- ✓ Түнхэл тосгоны Захирагчийн алба нь 20 нэр төрлийн,

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ИТХ	1	16,504.7			1	16,504.7	1	16,504.7				
ЗДТГ	3	85,866.7			3	85,866.7	1	44,533.5	2	41,333.2	2	41,333.2
Ойн анги	1	160.0			1	160.0					1	160.0
Хэрх тосгоны захирагчийн алба	2	13,965.9			2	13,965.9	2	13,965.9				
Нийт дүн	7	116,497.3			7	116,497.3	4	75,004.1	3	41,493.2	3	41,493.2

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ	4	33,519.5	1	631.5	1	27,527.3	2	5,360.7				
ЗДТГ	5	96,293.8	1	2,575.5	2	60,752.1	3	32,966.2				
Хэрх тосгоны Захирагчийн алба	2	1,076.6			1	1,076.6	1					
Түнхэл тосгоны Захирагчийн алба	2	1,091.0			1	1,091.0	1					
Ойн анги	3	7,135.1			1	849.1	2	6,286.0				
Дүн	17	144,684.7	2	3,207.0	6	96,864.8	9	44,612.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж
	Төлбөрийн акт		Төлбөрийн акт		Төлбөрийн акт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	1						1
ЗДП-4 мэдээллийг хугацаа хоцроосон							
ИТХ-1 мэдээллийг хугацаа хоцроосон							
Түнхэл тосгоны Захирагчийн алба-15 мэдээллийг хугацаа хоцроосон	1						1
Дүн							
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Хөрөнгө оруулалтад тусгаж хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардалд тусгаж, хэрэгжүүлсэн	1						1
Зураг төсөв боловсруулах төсөл арга хэмжээг ОНХС-ийн төсөвт бус ОНХО-ын төсөвт тусган баталж, хэрэгжүүлсэн.	1						1
Дүн	2						2
Нийт дүн	3						3